



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Г

**Журам батлах тухай**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.6 дах заалт, 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Мэндбаяр/, аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /М.Саранчимэг/-д даалгасугай.

ДАРГА



С.ЭРДЭНЭ

Нийгмийн даатгалын Үндэсний  
зөвлөлийн 2016 оны 03 дугаар сарын 25-  
ний өдрийн 06 дугаар тогтоолын  
нэгдүгээр хавсралт

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### *Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ*

1.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь заалтыг үндэслэн даатгуулагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээ (цаашид тусламж, үйлчилгээ" гэх) үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд явагдана.

1.3. Тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль, журмыг баримтална.

1.4. Сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд нь хяналт тавих үүргийг эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээнэ.

1.5. Тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалт явуулах хугацаа, эрүүл мэндийн байгууллагуудад тавигдах шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалыг эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

1.6. Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг орон нутгийн болон олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр 30 хоногийн өмнө зарлан мэдээлсэн байна.

1.7 Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь журмын 1.5-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслах мэргэжил арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүргийг улсын

хэмжээнд гүйцэтгэн холбогдох байгууллагуудад шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлнэ.

## Хоёр. СОНГОН ШАЛГАРУУЛАХ КОМИСС БАЙГУУЛАХ

2.1. Тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг уг журмын дагуу томилох, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийг Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага хэрэгжүүлнэ.

2.2. Тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах комисс нь дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан нийслэлд 15-21, орон нутагт 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Комиссын бүрэлдэхүүнд эрүүл мэнд, санхүү, эрүүл мэндийн даатгал, мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн байгууллагуудын төлөөлөл, мэргэжлийн холбоод, иргэний төлөөлөл орсон байна.

2.3. Сонгон шалгаруулалт зохион байгуулах бүрт комиссыг шинээр байгуулна.

2.4. Комисс нь сонгон шалгаруулалттай холбогдсон аливаа асуудлыг хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ.

2.5. Тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагууд 2 жил дараалан даатгалын гэрээгээ 98-аас дээш үнэлгээгээр дүгнэгдсэн тохиолдолд сонгон шалгаруулалтанд шууд тэнцүүлэх асуудлыг комиссын хурлаар шийдвэрлэж болно.

2.6. Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь комиссын үйл ажиллагаа хэвийн явуулах болон журам хэрэгжүүлэхэд-мэргэжил,- арга зүйн удирдлага,- нөхцөл, бололцоогоор хангана.

## Гурав. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

3.1. Уг журмын 2.2-т заасан комиссын нарийн бичгийн дарга нь зарласан хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн материалыг зохих журмын дагуу бүртгэн хүлээн авч, битүүмжилсэн хэвээр нь сонгон шалгаруулах комисст хүлээлгэн өгч, акт үйлдэн баталгаажуулна.

3.2. Комисс нь сонгон шалгаруулалтыг дараах дэс дарааллаар явуулна.

3.2.1. Сонгон шалгаруулалтад оролцогчдын төлөөллийг байлцуулан ирүүлсэн материал бүрийн битүүмжлэлийг шалган задалж, сонгон шалгаруулалтын материал бүрэн эсэх, зохих журмын дагуу

үйлдэгдсэн эсэхийг шалгаж, шаардлага хангасан материалуудыг бүртгэн авах, шаардлага хангаагүй материал ирүүлсэн эрүүл мэндийн байгууллагуудад мэдэгдэх;

3.2.2. Комиссын гишүүд ирүүлсэн материал бүртэй танилцаж, сонгон шалгаруулалтад орох байгууллагуудад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ өгөх;

3.2.3. Сонгон шалгаруулалттай холбоотой санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;

3.2.4. Сонгон шалгаруулалтын дүнг комиссын хурлаар хэлэлцэн шийдвэр гаргана. Комиссын шийдвэрт дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн нэгдсэн шийдвэр гаргуулах;

3.2.5. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан ажлын тайланг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлэх;

3.2.6. Сонгон шалгаруулалтын дүнг мэдээлэх;

3.3. Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэн “Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ үзүүлэх, худалдан авах гэрээ” байгуулах үйл ажиллагааг эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төв, орон нутгийн байгууллага зохион байгуулна.

#### Дөрөв. СОНГОН ШАЛГАРУУЛТАНД ОРОЛЦОХ БАЙГУУЛЛАГУУДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Сонгон шалгаруулалтад орж буй эмнэлгийн байгууллагууд дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1. Эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх;

4.1.2. Магадлан итгэмжлэгдсэн байх;

4.1.3. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа стандартын шаардлага хангасан эмнэлгийн зориулалтын /орон сууцны барилга байгууламжаас ангид/ болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх, зорчих нөхцөл, боломж бүхий байртай байх;

4.1.4. Хяналтын эрх бүхий байгууллагаас тавьсан акт, албан шаардлагын биелэлт хангагдсан байх;

4.1.5. Тусгай зөвшөөрлийн дагуу үзүүлэх тусламж үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн хүний нөөцөөр хангагдсан, их эмч болон эмнэлгийн мэргэжилтэн тухайн эмнэлгийн үндсэн ажилтаны 90-ээс доошгүй хувийг эзэлсэн байх;

4.1.6. Эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх;

4.1.7. Эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагааг бүртгэх, статистик мэдээлэл, тайлан мэдээ гаргах, эрүүл мэндийн даатгалын цахим мэдээллийн сүлжээнд холбогдох, харилцах, мэдээлэл дамжуулах, нэхэмжлэх зэрэг үйл ажиллагаа бүрэн цахим хэлбэрт шилжсэн байх;

4.1.8 Даатгуулагчдын сэтгэл ханамж судалгаагаар 80-аас доошгүй хувьтай байх;

4.2. Сонгон шалгаруулалтад орж буй өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг нь дараах шаардлагыг хангасан байна:

4.2.1. Эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх;

4.2.2. Магадлан итгэмжлэгдсэн байх;

4.2.3. Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа "MNS5081:2013", "Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа "MNS5292:2011" стандартын шаардлага хангасан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх, зорчих нөхцөл, боломж бүхий байртай байх;

4.2.4. Зарим сэргээн засах, гэрээр үзүүлэх, өдрийн болон оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэхэд холбогдох журам, стандарт шаардлагыг хангасан байх;

4.2.5 Даатгуулагчдын сэтгэл ханамж судалгаагаар 80-аас доошгүй хувьтай байх;

4.3. Сонгон шалгаруулалтад орж буй сувилал нь дараах шаардлагыг хангасан байна.

4.3.1. Эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх;

4.3.2. Магадлан итгэмжлэгдсэн байх;

4.3.3. Сувилал нь “Сувиллын бүтэц үйл ажиллагаа MNS 5232:2013” стандартын шаардлага хангасан байх;

4.3.4. Эрүүл агаарт байгалийн нөөцөт газрыг түшиглэн, рашаан, шаерын нөөц нь эмчилгээний ач холбогдолтой гэдгийг тогтоосон эрх бүхий байгууллагын баталгаажилттай, хот суурин газраас 20-иос доошгүй км хол байрласан, зориулалтын барилга байгууламжийн ашигтай талбайн 40-өөс дээш хувийг сувиллын тусламж, үйлчилгээнд зориулах байртай байх;

4.3.5. Хяналтын эрх бүхий байгууллагаас тавьсан акт, албан шаардлагын биелэлт хангагдсан байх;

4.3.6. Тусгай зөвшөөрлийн дагуу үзүүлэх тусламж үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн хүний нөөцөөр хангагдсан, их эмч болон эмнэлгийн мэргэжилтэн тухайн эмнэлгийн үндсэн ажилтаны 90-ээс доошгүй хувийг эзэлсэн байх;

4.3.7. Эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх;

4.3.8. Сувиллын өдөр тутмын үйл ажиллагааг бүртгэх, статистик мэдээлэл, тайлан мэдээ гаргах, эрүүл мэндийн даатгалын цахим мэдээллийн сүлжээнд холбогдох, харилцах, мэдээлэл дамжуулах, нэхэмжлэх зэрэг үйл ажиллагаа бүрэн цахим хэлбэрт шилжсэн байх;

4.3.9. Тусгай зөвшөөрөлд заагдсан тусламж, үйлчилгээ үзүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцтэй, эрх зүйн баримт бичиг, эмнэлзүйн удирдамж, холбогдох стандартын хэрэгжүүлэлт бүрэн төлөвшсөн байх;

4.3.10. Даатгуулагчдын сэтгэл ханамж судалгаагаар 80-аас доошгүй хувьтай байх;

4.4. Сонгон шалгаруулалтад орж буй эмийн сан нь дараах шаардлагыг хангасан байна:

4.4.1. Эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх;

4.4.2. Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандартыг хангасан байх;

4.4.3. Эмийн жорыг хянах нарийн мэргэжлийн мэргэшсэн эм зүйчтэй байх;

4.4.4. Эмийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг бүртгэх, статистик мэдээлэл, тайлан мэдээ гаргах, эрүүл мэндийн даатгалын цахим мэдээллийн сүлжээнд холбогдох, харилцах, мэдээлэл дамжуулах, нэхэмжлэх зэрэг үйл ажиллагаа бүрэн цахим хэлбэрт шилжсэн, зохицсон байх;

4.4.5. Улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанар аюулгүй байдал нь итгэмжлэгдсэн лабораториор батлагдсан эмийг борлуулдаг байх.

#### Тав. БУСАД ЗҮЙЛ

5.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулахад холбогдох албан тушаалтан комиссын үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхийг хориглоно.

5.2. Сонгон шалгаруулахтай холбогдсон асуудлаар гарсан маргааныг сонгон шалгаруулах комисс шийдвэрлэнэ.

---oOo---

---

